

ЁС СУРТАХУУНЫ СУРГААЛ БА НИЙГМИЙН

ФИЛОСОФИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Ш.Ганхуяг- МУИС-ийн Философийн тэнхмийн дэд профессор

Түлхүүр үг: Мэдлэг, сэтгэхүй, ухамсар, ёс суртахуун, хамтын ажиллагаа, нийгмийн харилцаа, энэрэнгүй үзэл, эршүүд императив, түгээмэл зарчим, эрх чөлөө

Товч утга: Философид асуудлыг онтологи, гносеологи, ёс суртахуун, нийгмийн философи зэрэг олон салбарт тал бүрээс нь авч үздэг. Эртний философичдын номлол сургаалыг судалж үзэхэд нэг салбар дахь үзэл баримтлалаас нөгөө салбар дахь үзэл баримтлал зайлшгүй урган гарсан байдаг нь уг судлагдахуун өөрөө хуваагдмал биш, бүхэл нэгдмэл чанартай болохыг илэрхийлнэ. Тухайлбал, танин мэдэхүй, ёс суртахууны хүрээнд яригдах асуудлууд нь нийгмийн философийн асуудалтай зайлшгүй холбоотой байдаг. Философийн эдгээр салбаруудын харилцан хамаарлыг зарим өрнийн философичдын үзэл баримтлалаас жишээ авч тайлбарлая.

Сэргэн мандалтын үеийн философич Мишель Монтень (1533-1592) хүнийг "ерөнхий хүн" гэсэн утгаар биш, харин тодорхой, жирийн л нэг бие хүн гэсэн утгаар авч үздэг аргазүйг дахин сэргээх цаг болсон гэж үзэж байгаагаа тэмдэглэе. Бие хүн бол бие, сэтгэл, ёс суртахууны нэгдэл бөгөөд байгаль ертөнцтэй салшгүй холбоотой. Хүнд ашигтай юм бүхэн байгаль эхэд ашигтай байх ёстой. Хүний сэтгэлийг хангаж байгаа бүхэн байгаль эхийн сэтгэлийг хангах учиртай. Хувь хүний сэтгэл байгаль эхийн сэтгэлтэй нэгддэг. Гэхдээ байгалийн эрх ашгийг умартсан хувь хүний ашиг сонирхлын үүднээс бусдад тулгасан шаардлага, эсвэл уламжлалт хуучинсаг үзэлд захируулах оролдлого нь "нийгмийн төлөө" хэмээх баг өмсгөлд нуугдсан байдаг. Байгальтай зохицсон бие хүний эрх чөлөөг тунхагласан Монтений сургаал нь түүхэн ач холбогдолтой байсан юм.

Шинэ үеийн философичдоос танин мэдэхүйн асуудал хэрхэн ёс суртахуун, нийгмийн асуудалд зайлшгүй холбогдох учир зүйг гаргасан анхны сэтгэгч бол Фрэнсис Бэкон билээ. Тэрээр: "Хүмүүсийн үнэнийг танин мэдэх гэсэн оюун ухааныг хязгаарлаж байдаг дөрвөн төрлийн хий үзэгдэл (төөрөгдөл) байна. Тэдгээрийг судлахын тулд тэдэнд нэр өгье. Эхнийг төрлийн хий үзэгдэл, хоёрдахийг агуйн хий үзэгдэл, гуравдахийг зах зээлийн хий үзэгдэл, дөрөвдэхийг театрын хий үзэгдэл гэж нэрлэе. ...Төрлийн хий үзэгдэл нь хүний өөрийн мөн чанарыг үндэслэдэг. Учир нь хүний мэдрэмж бол юмсыг хэмжих хэмжүүр гэж батлах нь буруу. Үүний эсрэгээр, мэдрэхүйгээрээ ч бай, ухаанаараа ч бай төсөөлөл нь хүмүүнд хамааралтай зүйл болохоос ертөнцөд хамаарахгүй. Хүний ухаан нь юмсын шинж чанарт өөрийнхөө шинж чанарыг хутган, юмсыг гажуудуулан тусгах нөлөөт тольтой адил. Агуйн хий үзэгдэл нь тусгаар хүний төөрөгдөл юм. Хүмүүний төрөлд төрсөн бүхэн алдаа гаргадаг нь зүйн хэрэг боловч түүнээс гадна хүн бүхэн байгалийн гэрлийг гажуудуулдаг өөрийн гэсэн онцгой агуйтай байдаг. Энэ нь төрөлхийн онцгой чанар, эсвэл хүмүүжил, харилцаа, уншсан ном, дээдэлдэг хүн, төсөөлөл сэтгэгдэл нь тэнцвэртэй тайван байх эсэх зэрэг өөр олон зүйлээс хамаарна. Хүмүүс агуу том, ерөнхий ертөнцөөс биш, харин бага жижиг ертөнцөөс мэдлэг эрж хайдаг хэмээн Гераклит зөв хэлжээ. Хүмүүсийн харилцаа холбооноос үүсдэг хий үзэгдлүүд ч бас байна. Эдгээр хий үзэгдлийг хүмүүсийн харилцаа, нөхөрлөлийг үүсгэдэг болохоор нь зах зээлийн хий үзэгдэл хэмээн нэрлэж байна. Хүмүүс хэл яриагаараа нэгддэг. Үг нь олны ухаанаар бүрэлдэнэ. Иймээс байраа олоогүй муу үг нь оюун ухааныг гайхалтай түгждэг. Эрдэмтэй хүмүүсийн хэрэглэж өөрийгөө хамгаалдаг тодорхойлолт тайлбарууд нь үйл хэрэгт яагаад ч тус болохгүй. Үгс нь оюун ухааныг шууд хүчиндэнэ, бүх юмсыг хольж хутгана, хүмүүсийг хоосон

хэрүүл шуугианд хатгана. Эцэст нь философийн янз бүрийн номлол, баталж нотолсон гэж хуулиуднаас хүмүүсийн сэтгэлд суурилсан хий үзэгдэл байдаг. Хэдий хэр хүлээн зөвшөөрөгдөж боловсорсон философийн систем байна, төдий хэмжээний хиймэл зохиомол ертөнцийг үзүүлэх жүжгүүдийг тоглосон байдаг хэмээн бид үзэж байгаа учраас тэдгээрийг *театрын хий үзэгдэл* хэмээн нэрлэж байна. Ингэхдээ бид ерөнхий философийн сургаалуудыг төдийгүй домог үлгэр, сүсэг бишрэл, хайш яаш байдлаар хүчээ авсан шинжлэх ухааны олон тооны дүрэм аксиомуудыг энд хамруулна⁷⁷ гэсэн байдаг. Ийнхүү мэдлэг ч бай, харилцаа ч бай, хувийн зан чанар ч бай, номлол сургаал ч бай бүгд хүмүүсийг жинхэнэ бодит үнэнээс холдуулдаг хэмээн үзсэнээрээ танин мэдэхүй, ёс суртахуун, нийгмийн харилцааны нэгдмэл, өөрийн гэсэн өвөрмөц мөн чанарыг дэвшүүлсэн хэрэг болно.

Декартын хувьд тэрээр ёс суртахууны үнэнийг оюун ухааны бодит үнэнээс гарган авсан байдаг. Төгс бодит байдал гэдэг бол хайр дээр тогтох ёстой, оюун санаа матери хоёр эсрэг тэсрэг зүйл биш, ертөнц хязгааргүй гэдгээр ертөнц ухаалгаар оршин тогтож байна гэдгийг баталж болно, ертөнц дээрхи бүхий л юм үзэгдэл ба хүн төрөлхтөн өөр хоорондоо салшгүй уялдаа холбоотой гэх мэтээр тэр бичсэн байдаг. Энэхүү нэгдлийг ухаарснаар нэгж юм үзэгдэлд шунан хүсэх сэтгэл арилж түгээмэл хайрын сэтгэл үүсдэг ба ийм хайр нь бидний цэвэр сэтгэлгээ болно гэж тэр үзсэн байна. Харин нийгэмд амьдрахдаа хүн тэрхүү сэтгэлээ нуун далдалдаг гэжээ.

Харин Гоббсын үзлээр нийгмийн гаднах байгалийн харилцааг хүмүүс харилцан тохиролцсон нийгмийн хэлцлээр зогсоосон байна. Ийнхүү хүмүүсийн байгалийн хүсэл шуналыг ёс суртахуун дардаг. Гэхдээ ёс суртахууны үндэс нь байгалийн хууль гэж Гоббс үзсэн. Тэрхүү байгалийн хуулийг өөрийгөө хадгалан хамгаалж хэрэгцээгээ хангах явдал гэж тодорхойлсон байна. Нийгмийн хэлцлээр тогтоосон иргэний үүрэг нь ёс суртахууны хуультай агуулгаараа тохирдог гэж Гоббс үзжээ. Гоббсын энэхүү үзэл дараа дараагийн философичдын үзэлд гүн нөлөөлсөн байдаг.

Спинозагийн үзлээр сэтгэлгээ бол ертөнцийн зайлшгүй чанар гэнэ. Сэтгэлгээнд сэрэл, сэтгэл хөдлөл, оюун ухаан бүгд хамаарна. Нэгэнт сэтгэлгээ нь сэтгэгч субстанц мөн юм бол хязгааргүй оюун санааны модус байх нь гарцаагүй. Сэтгэлгээ нь субстанцийн атрибут чанар юм бол аливаа нэгж юм үзэгдэл бүхний чанар мөн гэсэн үг⁷⁸ хэмээн Спиноза үзсэн байна. Сэтгэлгээний нэгж илрэл бүрийг Спиноза санаа хэмээн нэрлэжээ. Хүмүүст байдаг санаа нь хүмүүсийн биеийн бүтэцтэй холбоотой хэмээн тэрээр үзсэн байдаг. Чухам үүгээр танин мэдэхүйн үйл ажиллагаа тайлбарлагдана. Хүний сэтгэл санааны хамгийн гол хүчин зүйл нь сэтгэлийн хөдөлгөөн гэж Спиноза тайлбарладаг. Сэтгэл хөдлөлийн улмаас хүн оюун санааны бүрэн эрх чөлөөг олж чаддаггүй гэжээ.

XVIII зууны Европын нийгмийн амьдралын нөхцөл байдал нь хөрөнгөтний нийгмийн харилцаан дахь ёс суртахуун, нийгэм-улс төр, хууль-эрх зүйн асуудлуудыг философийн үүднээс тайлбарлаж, үзэл санааны ерөнхий удирдамж, чиг хандлагыг тодорхойлохыг зүй ёсоор шаардаж байсан юм. Нийгмийн энэ шаардлагад хамгийн нийцтэй зарчмуудыг И.Кант ёс суртахуун, нийгмийн философийн үзэл санаагаараа дэвшүүлэн тавьсан байдаг. Тэрээр нэгэнт бий болсон нөхцөл байдал бүхэн өөрийн гэсэн хууль зарчмыг бий болгодог бөгөөд тэрхүү хууль зарчмыг ухамсарлах нь танин мэдэхүйн үйл ажиллагааны гол зорилт болохыг тодорхойлсон юм. Өөрөөр хэлбэл, аливаа дэг жаяг, хууль зарчим, хэм хэмжээ гэдэг бол тухайн оршин буй нөхцөл

⁷⁷ Ф.Бэкон. Новый органон. Соч. 2-х томах. М. 1977

байдалдаа зохицдог гэж үзжээ. Бүх зүйл өөрийн гэсэн зохицолтой, хууль зарчимтай, цаад гүн утгаараа ухаалгаар зохион байгуулагдсан байдаг. Хүмүүс өөрсдийн тогтоосон хэм хэмжээгээ зөрчдөг боловч байгалиас нэгэнт зохицож бүрэлдсэн хууль зүй тогтлыг өөрчилж чаддаггүй. Ийнхүү хүмүүсийн боловсруулсан нийгмийн хууль зарчим ба орчлон ертөнцийн өөрийнх нь бий болгосон байгалийн зохицол нийцэл, хууль зүй тогтлын хооронд ялгаа байгааг И.Кант тэмдэглэжээ.

Мөн И.Кантын үзлээр, "орчлонгийн ёс суртахууны хууль ба эрх чөлөө хоёр хоорондоо зохицдоггүй. Гэхдээ энэхүү зохицол нь үзэгдлийн ертөнцөд биш, харин ухамсрын ертөнцөд боломжтой"⁷⁸. Хүн танин мэдэхүйн хувьд үзэгдлийн ертөнцөөр хязгаарлагддаг, трансцендент ертөнц рүү нэвтэрч чаддаггүй бол ёс суртахууны хувьд эрх чөлөөт дур хүслийг хүлээн зөвшөөрөх ёстой болдог. "Эрх чөлөө", "үхэшгүй мөнх", "бурхан" зэрэг нь ухамсрын ертөнц юм. Тэдгээр нь оршин байгааг онолын хувьд хэн ч баталж чадахгүй, энэ бол зөвхөн "практик оюун ухааны" зайлшгүй шаардлага юм. Онолын оюун ухаанаар батлагдаагүй зүйлийг практик оюун ухаанаар баталдаг. Хүн бол ёс суртахууны хэрэгсэл биш, харин зорилго нь юм. Танин мэдэхүйд бол энэ ертөнцийн оршихуйгаас, харин практик үйл ажиллагаандаа бол батлагдахгүй бөгөөд сүсэглэхээс өөр аргагүй трансцендент оршихуйгаас амьдрал эхэлнэ гэх мэтээр тэр номлосон байдаг.

Германы сонгодог философич И.Кантыг ёс суртахуун, улс төр, эрхзүйн салбарт тухайн цаг үедээ гол үүрэг гүйцэтгэсэн хүн гэж үздэг бөгөөд эдгээр салбар дахь түүний үзэл баримтлал нь танин мэдэхүйн сургаалаас нь урган гарсан гэж судлаачид тайлбарладаг. Харин Фихте нийгмийн философийн үзлээс танин мэдэхүйн сургаалаа гаргаж авснаараа онцлог философич байжээ. Фихтегийн философи дахь Би ба Би үгүйн ойлголтыг цэвэр онтологийн ойлголт болгон судлах хандлага өргөн бий. Үнэндээ Фихтегийн эдгээр ойлголт нь өрнийн философи дахь ёс суртахуун, нийгмийн философийн үзэл баримтлалын суурь үндэс болсон гэж хэлэхэд хилсдэхгүй. Хэрвээ И.Кант хүний мэдлэг бүрэлдэж боловсрох үйл ажиллагаа нь эцсийн эцэст нийт хүн төрөлхтний ёс суртахууны түгээмэл зарчмын шаардлагыг (категорический императив) тогтоодог, мэдлэг нь ёс суртахуунаас тусдаа биеэ дааж бүрэлдэж болох боловч ёс суртахууны хуулинд захирагддаг гэсэн үзлийг дэвшүүлсэн бол Фихте зөвхөн ёс суртахуун байгаа газар л мэдлэг боловсроно гэсэн хатуу байр суурьтай байжээ.

Фихтегийн үзлээр, "хүний сэтгэлгээ бодрол нь практик үйл ажиллагаатай нь, мэдлэг нь ёс суртахуунтай нь салшгүй холбоотой. Бодол санаа, үйл ажиллагаа, ёс суртахуун, мэдлэг боловсрол – бүгд хүний нэгэн бүхэл ухамсар оюун санааных нь өөр хоорондоо салшгүй холбоотой хэсгүүд юм. Ёс суртахуун алдагдахад мэдлэг боловсрол нь мөн алдагдана. Үйл ажиллагаа үгүй бол сэтгэн бодох чадвар ч алдагдана. Бодрол бясалгал үгүй бол ёс суртахуун үгүй болно"⁷⁹. Энэ мэтчилэн хүний оюун санааны ертөнц дэх бүх тал хэсгүүд өөр хоорондоо салшгүй холбоотой.

Үнэнийг олох гэсэн чин хүсэл эрмэлзэл сөрөг ёс суртахууныг аяндаа үгүйсгэнэ. Байгаль ертөнцийг танин мэдэх гэсэн хүний үйл ажиллагаа нь нийгмийн үйл ажиллагаа явуулахыг шаарддаг, харин нийгмийн үйл ажиллагаа нь сэтгэл үгүй аваас юунд ч

⁷⁸ Б.Рассел. История Западной философии. Новосибирск 1999

⁷⁹ Б.Рассел. История Западной философии. Новосибирск. 1999

хүрэхгүй, Орчлонгийн түгээмэл харилцан хамаарлыг үл ойшоосон ямар ч нийгмийн үйл ажиллагаа амжилт авчрахгүй. Фихте байгалийн хууль ба нийгмийн хуулийн харилцан хамаарлыг тогтоох зорилго тавьсан юм. Фихтегийн философи дахь Би хэмээх ойлголт нь хүний тасралтгүй үргэлжлэх оюун санааны үйл ажиллагааг илэрхийлдэг ба оюун санаа нь зөвхөн логик зөв бодомжийг төдийгүй түүний зорилго болох эцсийн үйл ажиллагаандаа ёс суртахууны түгээмэл зарчмыг мөрдөхийг зайлшгүй шаардлаг. Энэ бүхнийг хамран оюун санаа тасралтгүй үргэлжлэнэ. Оюун санаа буюу Би хэзээ ч тасрахгүй. Оюун санаандаа бодож тунгааж, сэдэж сэтгэж байгаа бүхэн хүний үйл ажиллагаагаар тасралтгүй үргэлжлэнэ. Бодролоос гарсан үйл ажиллагаа нь дараа дараагийн мэдлэгийг төрүүлдэг. Мэдлэгээс онол сургаал бий болно. Мэдлэгийн бүхий л агуулгыг оюун санааны идэвжилтээр өөрийн мөн чанараас гарган авдаг. Би – энэ ойлголтонд ухамсрын хамгийн анхны бөгөөд үндсэн зарчим агуулагдана.

“Би бол” гэдэг нь “Би” бол “би” гэсэн үг хэмээн Фихте тайлбарласан байдаг. Миний Би зөвхөн надтай л адил, өөр хэнтэй ч адил бус, хэнтэй ч зүйрлэшгүй, би бол би л байна. Би гэдэг бол намайг тодорхойлох цорын ганц зүйл. Би гэдэг бол миний бодол санаа, миний үйл ажиллагаа, миний ёс суртахуун. Бусдын талаар миний мэдлэг дульмаг байж болно, харин би өөрийгөө лавтай мэднэ. Ингэхлээр өөрөөсөө өөр зүйлсийн оршин байгаад нь би эргэлзэж болох боловч “би”-гийн оршин байгаад эргэлздэггүй. Гэвч өөрөөсөө өөр бусад зүйлсэд эргэлзэж байгаа нь түүний эсрэг өөрийнхөө оршин байгааг маргашгүй хүлээн зөвшөөрөх үндэслэл болж байна.

Гегелийн эрхийн онолд нийгмийн амьдралыг эрх чөлөөг хэрэгжүүлэх дэвшил гэж үзсэн байдаг. Тэрээр эрх чөлөөний ертөнцийг объектив оюун санаагаар дамжуулан тайлбарласан юм. Эрх чөлөөний өөрийн хөгжил бол эрх, иймээс объектив оюун санааны тухай сургаал нь эрхийн философи байна гэж тэр үзсэн. Эрхийн философид өмчийн эрх, ёс суртахууны эрх, гэр бүлийн эрх, төрийн эрх, олон улсын эрх, бүх дэлхийн түүхийн эрх буюу ертөнцийн оюун санаа гэсэн ойлголтууд нэгээс нөгөөд шилжинэ. Гегелийн “бодтой бүхэн зохистой, зохистой бүхэн бодтой” гэсэн санаа нь онтологи ба нийгмийн философийн асуудлыг нэгтгэсэн хэрэг. Түүний үзлээр ухаалгаар зохицуулагдсан бодит байдлын тухай сургаал ёсоор бодит байдалд ертөнцийн оюун санаа, дээд оюун ухааны зохицол илэрнэ. Ухаалаг зохистой байдал ба бодит байдал хоёр нь харилцан хамааралтай бөгөөд өөрийн үеэ өнгөрөөсөн нийгмийн ухаалаг биш байдал нь нийгмийн ухаан, нийгмийн зохицолд байраа тавьж өгч, өөрөө мөхөх тавилантай. Хийсвэр эрх зүй, ёс зүй, ёс суртахуун нь ертөнцийн оюун санааны тодорхой илрэл болох чөлөөт дур хүслийн хөдөлгөөнийг боловсруулагч үнэмлэхүй шат дараалсан илрэлүүд болно.

Гегелийн эрх зүй бол хувийн өмчтөний өөрийнх нь хүсэл сонирхлын илэрхийлэл болох объектив оюун санааны анхны шат юм. Дотоод оюунлаг чанараараа хязгааргүй бөгөөд ерөнхий түгээмэл хувийн хүсэл сонирхол гэдэг бол бие хүн мөн. Түүний эрхийн хэм хэмжээ нь хийсвэр эрх зүйн үндэс болох ба байгаль оршин ахуйг хувийн юм мэтээр үзэж үйл ажиллагаа явуулах явцдаа өөрийн субьектив хязгаарлагдмал байдлаа даван туулдаг. Хийсвэр эрх зүйн хүрээнд эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ хувийн өмчийн харилцаанд үндэслэнэ. Өмч нь бүхий л юмс үзэгдлийг эзэмших бие хүний хийсвэр эрх зүйг хэрэгжүүлдэг. Хувийн өмч бол өмчийн ухаалаг чанар мөн.

Гегелийн объектив оюун санааны өөрийн хөгжлийн хоёр дахь шат нь ёс зүй юм. Эрх зүйн бие хүн нь ёс зүйн бие хүн болж, өөрөө хөгжигч эрх чөлөө илүү дээд түвшинд гарна. Хориг цаазын агуулга бүхий хэлбэрийн эрх зүй нь ёс зүйн хүрээнд ирэхээрээ зөвхөн тухайн субьектын сайн сайхан байдал төдийгүй бусдын сайн сайхан байдлыг авч үзнэ. Субьектын ёс зүйн хүсэл сонирхлын илрэл нь үйл хэрэг мөн, улмаар ёс зүйн хүсэл сонирхлын эрх нь үйл хэргийн эрх мөн. Ёс зүйн зорилго нь янз бүрийн субьектуудын

үйл хэрэг хориг цаазын үр дүнгээр төдийгүй, тэдгээр субъектуудын дотоод сэтгэл санаанаас гарч байгаа тийм үйл хэргийн харилцан зохицолдоонд хүрэх замыг олох явдал юм. Хувийн өмчтөн нь өөрийгөө эрх зүйн бие хүн төдийгүй, ёс зүйн субъект хэмээн ухамсарлах ёстой. Энэ тохиолдолд тэрээр өрх гэрийн тэргүүн, иргэний нийгмийн гишүүн байж, эрх зүйн дээд хүрээ болох төрийн түшиг тулгуур болж чадна.

Объектив оюун санааны өөрийн хөгжлийн сүүлчийн гурав дахь шат нь эрх чөлөөг тодорхой болгож хэрэгжүүлсэн ёс суртхуун юм. Ёс суртхууны хүрээний объектив оюун санаа нь гэр бүл, иргэний нийгэм, төр гэсэн өөрөө өөрийгөө объектчлах гурвалын зам болой. Гэр бүл, иргэний нийгэм нь объектив оюун санааны эцсийн хэлбэрүүд мөн болохыг эцсийн хэлбэр болох төр батална. Хамгийн дээд гэр бүлд эрэгтэйчүүд ёс зүй-эрхийн талаас ноёрхож, эмэгтэйчүүд хүүхдээ төрүүлэн, гэр бүлийн аж ахуйгаа хөтлөх үүрэг хүлээж, хувийн өмч болон хүүхэд хүмүүжүүлэх үүрэгтэй. Иргэний нийгмийн бүрэлдэл хэсэг нь хувийн өмчид тулгуурласан хэрэглээний систем, түүнийг сахин хамгаалах шүүх эрх, цагдаагийн байгууллага юм. Объектив оюун санаа нь гэр бүл, иргэний нийгмийн шатыг туулж төрийн харилцаанд бүрэн боловсроно. "Иргэний нийгэмд тайж язгууртны давхраа нь хувийн өмчөөс дээш гарч төрийн засаглалыг хэрэгжүүлэгч дээд давхраа болдог. Төр орших нь ертөнцөд дээд эзэн тэнгэр заларч байгаа хэрэг, түүний үндэс нь оюун ухаан байж өөрийгөө дур хүслээр илэрхийлдэг. Өөрчлөгддөггүй, хувиа хичээсэн иргэний нийгэм ба дээд төр хоёрын эсрэг тэсрэг байдал нь үндсэн хуульт язгууртны хаант засагт эвлэрэн шийдэгдэж объектив оюун санаа бүрэн хэрэгждэг"⁸⁰ хэмээн Гегель үзжээ.

Энэ мэтчилэн философичид онтологийн үзлээсээ ёс суртахуун, улмаар нийгмийн философийн үзэл баримтлалаа дэвшүүлж ирсэн нь философийн эдгээр салбарууд өөр хоорондоо нягт холбоотой, нэгдмэл үзэл санааны салшгүй хэсгүүд болохыг илтгэж байна. Иймд нийгмийн философийн асуудлыг ёс суртахууны, бүр цаашлаад онтологийн асуудлаас хөөн судлах нь судалгааг нэгдмэл, бүрэн цэгцтэй болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

Орчин үеийн философи дахь позитив урсгалын эрт үеийн нэгэн төлөөлөгч Паскуале Виллари (1827-1917) "Түүхийн философи дахь гарал үүсэл ба дэвшлийн тухай", "Позитив түүх ба түүхэн арга" зэрэг зохиолдоо философи нь хүн төрөлхтний тухай бүхэл бүтэн, бүрэн дүүрэн мэдлэг олох гэсэн эрмэлзлээс татгалзах ёстой гэсэн байдаг. Баримт факт, нийгэм ёс суртахууны хууль зарчим, сэтгэл судлал ба түүхийн шинжлэх ухааны үр дүнг тэвчээртэй нэгтгэн харьцуулж хүн төрөлхтний оюун санааны хууль зарчмыг гаргах нь позитив философийн гол үүрэг болно хэмээн тэрээр тодорхойлжээ. Энд цаг хугацаа, орон зайгаас алслан хийсвэрлэсэн "хүн", "нийгэм" гэгч хоосон ойлголт категоруудын тухай биш, бодит амьд хүн, нийгэм, хүсэл шуналдаа хөтлөгдөн өөрчлөгдөн хувирагч хүн, нийгмийн тухай асуудал яригдах юм. Анхдагч хөдөлгөөнгүй гол мөн чанарыг тогтоох гэсэн метафизик нь өөрчлөлт хувиралтыг анзаардаггүй, гэтэл хүн, нийгэм бол тасралтгүй хувиран өөрчлөгдөгч үзэгдэл мөн бөгөөд үүнийг ойлгохын тулд тэрхүү өөрчлөлт хувьслын хууль зарчмыг ойлгох хэрэгтэй хэмээн Виллари бичжээ.

Харин Шпенглерийн үзлээр, "байгаль гэдэг нь бий болчихсон юманд бий болж байгаа юмыг захируулдаг бол түүх нь бий болж байгаа юманд бий болчихсон юмыг захируулна. Байгальд механик зайлшгүй үйлчлэнэ, түүхэнд органик зайлшгүй үйлчлэнэ. Байгалийг тооцоолол сэтгэлгээгээр ухаарна, түүхийг амсан мэдэрч ухаарна гэх мэтээр

⁸⁰ Г.В.Гегель. Философия истории. М., 1998

байгаль шинжлэл ба нийгмийн философийн ялгааг гаргасан байдаг. Адгуус амьтанд ямар ч зорилго чиглэл байдаггүйтэй адил хүн төрөлхтний түүхэнд ч зорилго чиглэл байхгүй⁸¹ хэмээн Шпенглер бичжээ.

Амьдралын философийг үндэслэгчдийн нэг В.Дильтей (1833-1911) нийгмийн амьдралын бүх үйл явц нь оюун санааны агуулгатай учраас хүн төрөлхтний түүх нь хувь хүний оюун санааны амьдралаас урган гарна гэж үзсэн байдаг. Дильтей нийгэм-соёлын амьдрал бол хүний ахуйн цорын ганц арга гэж үзээд нийгмийн түүх гэж байхгүй, хүний амьдрал өөрөө түүх юм, иймээс хүний амьдралыг ойлгох нь нийгмийн философийн гол зорилго гэж тайлбарлажээ. Дильтейн үзлээр нийгмийн философи бол утга учир, үнэ цэнэ, зорилго гэх мэт ойлголтуудаар илэрхийлэгдэх оюун санааны тухай шинжлэх ухаан мөн. Нийгмийн амьдрал нь нийгмийн байгууллага, төр улс, сүм хийд, шашны, хууль эрхийн, философийн, гоозүйн, ёс суртахууны системээрээ тусгаар шинжлэх ухааны судалгааны объект болдог. Энэхүү объектчлэл бол нийгмийн бүтцийн анхдагч шинж чанар мөн гэх мэтээр Дильтей бичжээ.

Орчин үеийн нийгмийн философид өргөн хэрэглэгдэж байгаа "нээлттэй нийгмийн" тухай үзлийг анх Г.Бергсон дэвшүүлэн тавьжээ. Тэрээр хаалттай нийгэм нь хаалттай үзэл санаа, хаалттай шашин, хаалттай хууль эрхийн системтэй адил статик, зогсонги шинжтэй бөгөөд харин нээлттэй нийгэм нь динамик, хөдлөнгө шинж чанараараа ялгарна гэж үзжээ. Хаалттай нийгмийн гишүүд нь анги бүлгийн үзэл санаанд баригдсан байдаг.

Харин нээлттэй нийгмийн гишүүд нь түгээмэл, универсаль ёс суртахуунтай байна. Энэ үзлийг Австрийн философич, социологич К.Р.Поппер 1945 онд бичсэн "Нээлттэй нийгэм ба түүний дайснууд" зохиолдоо хөгжүүлэн боловсруулжээ. Поппер шинжлэх ухааны философи болон нээлттэй нийгмийн үзэл санаагаараа алдаршсан юм. Тэрээр Венийн дугуйлан гэж алдаршсан орчин үеийн неопозитивизмын нэгэн том урсгалын төлөөлөгч гэж тооцогддог ч Витгенштейний нэгэн адилаар хэзээ ч тэр дугуйлангийн гишүүн байгаагүй юм. Гэхдээ неопозитивист урсгалын нэр хүнд муудсаны бурууг Поппер өөр дээрээ тохсон байдаг.

Харин Отто Нейрат түүнийг Венийн дугуйлангийн "албан ёсны шүүмжлэгч" гэж нэрлэжээ. Учир нь Попперийн хамгийн их хэлдэг үг, баримталдаг зарчим нь "шинжлэх ухааныг хүн бүтээдэг учраас алдаа гаргах чадвартай байх ёстой" гэдэг. Шинжлэх ухааны мэдлэг батлагдсан байх ёстой гэсэн (верификацийн) баримтлалыг няцааж, харин ч шинжлэх ухааны үнэн нь байнга няцаагдаж байж шинжлэх ухааны биш мэдлэгээс демаркац шинжээрээ ялгарч байдаг гэсэн (фальсификацийн) зарчмыг дэвшүүлсэн билээ. Ингэснээрээ нийгмийн философи дахь уламжлалт индуктив аргын оронд дедуктив аргыг хэрэглэсэн юм. Шинжлэх ухааны батлан нотолсон үг өгүүлбэрүүд нь үнэмлэхүй үнэн байж чадахгүй, харин хяналт шалгалтанд байнга өртөх магадлалтай үнэнийг тодорхойлж байвал илүү үр өгөөжтэй болно гэж үзсэнээрээ Поппер Венийн дугуйлангийнхнаас ялгарчээ.

Ийнхүү онтологи, гносеологи, ёс суртахуун, нийгмийн философи гэх мэт философийн салбар судалгааг нэгтгэн шинжлэх ухааны нэгдсэн аргазүйд оруулах хандлага сүүлийн үед давамгайлж байна.

⁸¹ Л.Шпенглер. Закат Европы. М. 1993

1. Б.Рассел. История Западной философии. Новосибирск 1999
2. Г.В.Гегель. Философия истории. М. 1998
3. К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. УБ. 2005
4. Л.Шпенглер. Закат Европы. М. 1993
5. Ф.Бэкон. Новый органон. Соч. 2-х томах. М. 1977
6. Ш.Ганхуяг, М.Гантуяа. Философийн түүхэн тойм. УБ., 2002
7. Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ. 2006